БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**

17042 Улаанбаатар хот , Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Б.Шаравын гудамж-6, Хан-Уул тауэр, 1201 тоот
Утас: +976-70140166, 70140188,
Э-шуудан: piubaccp@gmail.com,
http://www.baccp.mn

2025.12.03 № 25/272

танай ______________ -ны № ______________-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ГАЗАРТ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын тусламж авах, зарцуулах удирдах, бүртгэх тайлагнах журам"-ийн 17.1 дэх заалтыг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны (БОУАӨЯ), Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар Төслийн үйл ажиллагааг шалгах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг төслийн 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаа төлөвлөгөө, зөвлөх бөг, төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан хаагчдын хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийг үнэлэх, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодитой мэдээллээр хангах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нэгж (ТХН)-д хяналт-үнэлгээ хийж, тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн. Тус ажлын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр төслийн удирдлагуудад танилцуулсан ба үүний дагуу төслийн үйл ажиллагааг сайжруулах талаар БОУАӨ-ийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/355 тоот тушаал гарсан.

Төслийн үйл ажиллагааг сайжруулах тушаалын биелэлт болон төсөл хэрэгжүүлэх нэгж, мөн зөвлөх багт ирүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, түүний дүгнэлтийн тайлбар болон зөвлөмжөөр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна. Төслийн үйл ажиллагааг сайжруулах тушаалын биелэлтийг нэгдүгээр хавсралт, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн тайлбар, зөвлөмжийн биелэлтийг хоёрдугаар хавсралтаар, төслийн зөвлөх багт ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус хүргүүлж байна.

Хавсралт .... хуудастай.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ М.ТУЛГА

УЛААНБААТАР ... БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ ТБАГ 9020070899 ... 6599737

003697

**Хавсралт-1**

**Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-ийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах тухай А/355 тоот тушаалын биелэлт**

(2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар)

| № | Тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар | Биелэлт | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-ийн санхүүжилтийн гэрээний дагуу Сэргээн Босголтын зээлийн банктай зөвшилцөж, Еко консалт сепп ба Бусакер болон Gitec-Igip хамтарсан зөвлөх баг компанид санхүүгийн аудит оруулах. | | Төслийн зөвлөх багт санхүүгийн аудит оруулах ажлыг захиалагч тал хэлэлцэж шийдвэр гаргана. Тус тушаал, түүнд өгөгдсөн үүрэг даалгаврыг талуудад танилцуулсан болно. |
| 2 | “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-ийн нэгжийн бүтцийн санхүүжүүлэгч байгууллагын саналаар шинэчлэн батлах. | | Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцийн санхүүжүүлэгч байгууллагын саналаар шинэчлэн батлах тухай саналыг 2025 оны 06 дугаар сард БОУАӨЯ (захиалагч тал) хүргүүлж, баталгаажуулан саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Тус саналыг Монгол улсын Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 дугаар тушаал, түүний хавсралтаар батлагдсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”-ыг мөрдөх чиглэл ирсний дагуу батлаагүй. Иймд яамдуудад хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг нэгтгэн нэгдсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж байгуулах чиглэл ирүүлсний дагуу төслийн бүтэц орон тоог шинэчлэн батлах ажлыг захиалагч талтай хэлэлцэж байна. |
| 3 | “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-ийн арга хэмжээ, үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө, тухайн жилийн нарийвчилсан төлөвлөгөө, түүнд үндэслэн | Төсөл арга хэмжээ, үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөөг буюу сүүлийн хоёр жилийн хугацаанд (2025-2026) хэрэгжих “Стратегийн төлөвлөгөө”-г Зөвлөх багтай хамтран боловсруулж, БОУАӨЯ ба санхүүжүүлэгч талаар баталгаажуулсан. Тус | |

| | | | |
|---|---|---|---|
| | худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах. | төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн нарийвчилсан төлөвлөгөө, түүнд үндэслэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн талуудаар баталгаажуулсан. | |
| 4 | “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-ийн арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах, үр дүнг хариуцах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд удирдан зохион байгуулж ажиллахыг төслийн захиралд үүрэг болгосугай. | | Төслийн арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд удирдан зохион байгуулан ажилласан. |
| 5 | “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-ийн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, үр дүнг танилцуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, биелэлтийг дүгнэж, явц, үр дүнг төслийн захирал, төслийн удирдах хороонд танилцуулж ажиллах | Төсөл арга хэмжээний үр дүнг хагас жилийн байдлаар дүгнэн талуудад танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг тайланг бэлтгэн 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар БОУАӨЯ-ны Хяналт үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. Тайлбар, зөвлөмжийн биелэлтийг төслийн удирдах хороонд танилцуулахаар бэлтгэн ажиллаж байна. | |
| 6 | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны (хуучин нэр), Еко консалт сепп ба Бусакер болон Gitec-Igip компанитай 2020 оны 02 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “Зөвлөх ажлын гэрээ”-г дүгнэж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулахыг Гадаад хамтын ажиллагааны газар, Хуулийн хэлтэст тус тус үүрэг болгосугай. | | Зөвлөх багийн ажлын гэрээг дүгнэж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулах ажлыг захиалагч хэлэлцэж шийдвэр гаргана. Тус тушаал, түүнд өгөгдсөн үүрэг даалгаврыг талуудад танилцуулсан болно. |
| 7 | “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл”-өөс нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн тооллогыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, өмч хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлж, ашиглалтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах | Энэ ажлын хүрээнд нийт хөрөнгө орлогод бүртгээгүй үлдсэн тоног, төхөөрөмжийг хөрөнгө, орлогод бүртгэх, тухай БОУАӨЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 09/2577 дугаартай албан бичгийг төслийн хүрээнд санхүүжилт авсан нийт 147 байгууллагад хүргүүлэн тайлан мэдээг нэгтгэсэн. Төслийн 2025 оны хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөний дагуу 3 | |

| | | | |
|---|---|---|---|
| | | чиглэлд хяналт үнэлгээ, хөрөнгө ашиглалт, үр дүнд мониторингийн ажлыг зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд 9 аймгийн 17 Улсын тусгай хамгаалалттай газар (УТХГ), 9 Байгаль орчны газар (БОГ), 11 Ерөнхий боловсролын сургууль (ЕБС), 4 Ус цаг уур орчны шинжилгээний газар (УЦУОШГ), 4 Сав газрын захиргаа(СГЗ), 4 Ойн анги, 8 Эрүүл мэндийн төв, 12 Хүлэмж ашиглагч, 25 Усалгааны төхөөрөмж ашиглагч нарын төслийн хүрээнд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх, ашиглалтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. Орон нутгийн хяналт мониторинг, хөрөнгө бүртгэл, үр дүнгийн тайлан илтгэх хуудас, нэгдсэн тайлан болон хөрөнгө оруулалтын бүртгэл, үр дүнг нэгтгэсэн байдлаар төслийн захирал, санхүүжүүлэгч талуудад тайлагнасан. Хэрэгжилт үр дүнг, дараагийн удирдах хорооны хуралд танилцуулахаар бэлтгэсэн. | |

**Хавсралт-2**

**Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төслийн 2022-2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн дүгнэлтийн тайлбар, зөвлөмжийн биелэлтийн тайлан, мэдээлэл**

(2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар)

| **Төслийн хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны хүрээнд өгөгдсөн дүгнэлтийн тайлбар мэдээлэл** | | | |
|---|---|---|---|
| **№** | **Хяналт-шинжилгээний ажлаар өгсөн дүгнэлт** | **Хавсралт, эх сурвалж** | **Тайлбар** |
| 1 | Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төслийн жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 2022 онд 82 хувь, 2023 онд 75 хувь, болон 2024 онд 65.7 хувьтай байна. | Удирдлагын мэдээллийн сан https://odamis.mof.gov.mn/mdobject/dataview/1583295320606173?mmid=1590131997043742&mid=1590131997043742 | Нийт төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг 2022-2024 онуудад бүрэлдэхүүн, ажил бүрээр авч үзвэл:<br>- Нийт 3 жилийн хугацаанд 167 ажил төлөвлөсөн байна. Үүнээс 100 хувь биелэлттэй 105 ажил, 30-70 хувь биелэлттэй 19 ажил, 0 хувь биелэлттэй 33 ажил, үнэлэгдээгүй 10 ажил байна. Эдгээр ажлуудын гүйцэтгэлүүдийн хувьд авч үзвэл.<br>- Тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх, болон зөвлөх үйлчилгээний ажлууд нь ажлын даалгавар баталгаажсан даруй хугацаандаа хэрэгжиж талуудад хүлээлгэн өгсөн бүрэн хэрэгжсэн.<br>- 0 хувь үнэлгээтэй ажлууд ажлын даалгавар хугацаандаа боловсруулагдаж, баталгаажиж төлөвлөсөн хугацаанд ирээгүй нь тухайн ажил хэрэгжихгүй байх үндэслэл болсон.<br>- Барилгын ажил, Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан (ОБЗЭС), зарим ажил, бараа, үйлчилгээ зэрэг томоохон үнийн дүнтэй ажлууд нь дараах шалтгааны улмаас хойшилж хугацаандаа хэрэгжээгүй, хэрэгжилтийн үнэлгээ бага, он дамнасан, үнэлээгүй зэрэг байна Үүнд:<br>- Тендерт шаардлага хангасан оролцогч ирээгүй.<br>- Гэрээт ажлуудын санхүүжилтийг олгох, дүгнэх ажил захиалагч болон санхүүгийн эрх олгох байгууллагуудад удааширч ажил бүрэн хэрэгжихэд сөргөөр нөлөөлсөн. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | - Говийн их дархан цаазат газрын (ГИДЦГ) “Б”-ийн барилга захиалагч болон санхүүжүүлэгч талын саналаар зураг төсөл, ажлын даалгаврын шаардлага олон дахин өөрчилсөн тул үнэлээгүй.<br>- Төслийн I дүгээр үе шатны ОБЗЭС-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн Эс Ай Си Эй ХХК-ний тайлан, дүгнэлтэд үндэслэн ОБЗЭС-ийн концепц, дамжуулан зээлдэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагыг санхүүжүүлэгч тал (KfW) банкнаас тавьсан учраас II, III дугаар үе шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг санхүүжүүлэгч байгууллагаас түр түдгэлзүүлсэн учир үнэлээгүй.<br>- Ажлын даалгавар үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас хоцорсон.<br>- Гүйцэтгэгч байгууллагуудын гэрээний хэрэгжилт хугацааны сунгалттай холбоотой тухайн жилдээ бүрэн хэрэгжээгүй он дамнасан, зэрэг ажлууд нь өнгөрсөн 3 жилийн ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.<br><br>Төслийн эхний хоёр жил Ковид-19 цар тахлын үе 2020 он, 2024 оны сонгуулийн дараах улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалж 2021-2024 онд төслийн захирал 8 удаа, удирдах хороо (УХ)-ны дарга, төслийн зохицуулагч тус бүр 3 удаа, захиалагч тал болох БОУАӨЯ-ны газар хэлтсийн дарга нарын ээлжлэн солигдож байсан нь төслийн үйл ажиллагаа (ҮА)-ны болон худалдан авах ажиллагаа (ХАА)-ны төлөвлөгөөг батлуулах, тендер шалгаруулалт, гэрээт ажлын гүйцэтгэл хүлээн авах, санхүүжилт олгох процесст сөргөөр нөлөөлсөн. Жишээ нь: 2024 оны төлөвлөгөө 2024 оны 03 дугаар сарын 01-нд захиалагчаар баталгаажсан. Энэ нь төлөвлөсөн ажлуудыг тухайн жилд багтаан бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж улмаар он дамжихад нөлөөлсөн. ТХН-ийн зүгээс төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд захиалагч талаас дэмжлэг үзүүлэх, улс төрийн хараат бус байлгах, төслийн үйл ажиллагааг богино хугацаанд үр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дүнтэй хэрэгжихэд талуудын оролцоо, дэмжлэг хэрэгцээтэй байгаа талаар жил жилийн үйл ажиллагааны тайлан, хяналт шинжилгээ үнэлгээ (ХШҮ)-ний тайлан болон УХ-ны хуралд танилцуулж ажилласан.<br><br>Цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг бодитой төлөвлөх, батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд хэрэгжүүлэх, тайлагнахад анхаарч ажиллах болно. |
| 2 | Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын тусламж авах, зарцуулах удирдах, бүртгэх тайлагнах журам"-ийн 7.2.2-д заасан “Төсөл арга хэмжээг дунд хугацаанд төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх”, төслийн хэрэгжилтийг уг төлөвлөгөөний хүрээнд үнэлэх 2020-2027 онд хэрэгжүүлэх, төслийн хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөгүй | Төслийн тусгай гэрээ - https://baccp.mn/uploads/d8f881108755bfbe41b57a51dfaa796a.pdf<br><br>Төслийн 2025-2026 оны Стратегийн төлөвлөгөө - https://docs.google.com/document/d/1mrhBIUFvHcgQ3haaYigASWQN9_8JeQN8/edit?usp=drive_link&ouid=113679666933298618261&rtpof=true&sd=true | Төсөл нь 2020-2025 онуудад дунд хугацааны төлөвлөгөөгүй ажилласан. Энэ нь дараах учир шалтгаантай. Үүнд:<br>Төсөл нь хоёр улсын засгийн газар хооронд байгуулсан Тусгай гэрээний 01 дүгээр хавсралтаар заасан 4 бүрэлдэхүүн, 16 индикатортай уялдуулан 2020-2026 оны 12 дугаар сарын эцэс хүртэл хэрэгжих бөгөөд жил бүр төслийн санхүүжүүлэгч тал Германы Сэргээн босголтын банк (KfW)-аас хөндлөнгийн үнэлгээ хийдэг. Тус үнэлгээний багийн гаргасан дүгнэлтэд тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөөг сайжруулан талуудаас санал авч, санхүүжүүлэгч талаас дахин зөвшөөрөл авсны үндсэн дээр төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлдэг. Өнгөрсөн 2024 оны 10 дугаар сард санхүүжүүлэгч талын (KfW) банкны хяналт үнэлгээний баг ажиллаж төслийн хэрэгжилтийн сүүлийн 2 жилийн хугацаанд мөрдөж ажиллах төлөвлөгөө гаргах чиглэл өгсний дагуу богино хугацаанд буюу 2025-2026 онуудад хэрэгжих Стратегийн төлөвлөгөөг Зөвлөх багтай хамтран боловсруулж, БОУАӨЯ ба санхүүжүүлэгч талаар баталгаажуулсан. Цаашид төсөл хэрэгжих хугацаанд тус Стратегийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. |
| 3 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3, 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаад тусламж авах, | БОАЖЯ-ны сайд Н.Уртнасан 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/5000 дугаартай албан | Төслийн хүрээнд доорх 2 барилга, байгаль хамгаалагчийн байрыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд |

| | | | |
|---|---|---|---|
| | зарцуулах, Удирдах, бүртгэх тайлагнах журам -ийн 21.2, Улсын Их Хурлын 2022 оны 72 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах хэмжээний тухай 1.3-д заасныг дурьдсаныг мөрдөөгүй Шинэ төсөл, арга хэмжээний зураг төсөв батлагдаагүй байхад 2023, 2024 оны төслийн төлөвлөгөөнд Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга, байгаль хамгаалагчийн 25 байр барих ажлыг үр дүнгүй болгож, төлөвлөлтийн алдаа гаргасан. | бичиг- Олон улсын тахь нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газарт хүргүүлсэн байна. | удаа дараа тусгаж ажилласан төлөвлөлтийн алдаа гаргасан.<br>Тус төлөвлөлтийн алдаа гаргасан нь дараах учир шалтгаантай Үүнд:<br><br>***Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилга***<br><br>Тус тусгай хамгаалалттай газар нутгууд (ТХГН)-ын хамгаалалтын захиргааны барилга барих БОАЖЯам (хуучнаар) Олон улсын Тахь групп нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газартай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилгын зураг төсөл, төсвийг 2021 онд хийлгэсэн ба тус төслийн хөрөнгөөр бариулах хүсэлтийг БОАЖЯ болон ГИДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа албан ёсоор гаргасны дагуу төслийн 2022-2023 оны төлөвлөгөөнд тусгасан.<br>Олон улсын Тахь групп (ОУТГ)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар" ГИДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилгын зураг төсөл, төсвийг 2021 онд хийлгэж хүргүүлсэн боловч төслийн санхүүжүүлэгч тал Германы Сэргээн босголтын банк (KfW)-аас зураг төслийг дахин хянан үзээд олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн сайжруулах, зарим шаардлагатай барилгуудын зургийг нэмж тусгах, тухайн барилгын ашиглалтын концепцийг боловсруулан ирүүлэх шаардлага тавигдсан учир 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажил цуцлагдсан.<br><br>Иймд ТХН-д БОАЖЯ-ны ТХБНУГ-ын (хуучны нэршил) даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 02/1052 дугаартай албан хүсэлт "ГИДЦГ-ын "Б" хэсгийн сургалт, мэдээллийн төвийн барилгын хөгжлийн концепци баримт бичгийг санхүүжүүлэгч тал KfW банкны төсөл хариуцсан ахлах менежер Нина Отто-д хүргүүлсэн. Барилгын зураг төслийг дахин нэмж сайжруулах, барилга бариулах ажлыг 2024 оны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөнд дахин тусгасан ч зураг төслийг олон улсын чанарын өндөр шаардлагад нийцүүлэх шалтгаанаар цуцлагдаж тухайн онд амжиж хийгдээгүй тул хойшлуулж 2025 оны төлөвлөгөөнд оруулсан.<br><br>***Байгаль хамгаалагчийн 25 байр барих ажил***<br><br>Төслийн I дүгээр үе шатанд хамрагдсан ТХГН-ын хамгаалалтын захиргаадад байгаль хамгаалагчийн хяналтын пост, байр барих ажлыг 2017 оноос хийж нийт байгаль хамгаалагчийн байр 48, сургалт мэдээллийн төв 3, бүсийн сургалт мэдээллийн төв 1-ийг барин хүлээлгэн өгсөн. Төслийн 1 дүгээр үе шатад барьсан байгаль хамгаалагчийн байрнуудыг ашиглах явцад ажиглагдсан сул талуудыг засаж сайжруулах, орон нутгаас ирсэн санал шүүмжлэлийг анхааран үзэж цаашид барих байгаль хамгаалагчийн байрыг байгалийн бүс бүслүүрийн онцлогт нийцүүлэн сайжруулах зорилгоор байгаль хамгаалагчийн байрны нэг загварын зураг төслийг боловсруулах чиглэлийг 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 09/4585 дугаараатай албан бичгээр төсөл хэрэгжүүлэгч нэгжид, БОАЖЯ-наас (хуучны нэршил) ирүүлсэн.<br><br>Иймд байгаль хамгаалагчийн байрны нэг маягийн зураг төслийг дахин боловсруулах ажлын гэрээг “Инженеринг Сэрвис Суппорт” ХХК-тай байгуулсан. Уг зураг төслийг 2025 оны 5 дугаар сард дуусган Барилга хөгжлийн төвөөр хянуулахаар хүргүүлсэн бөгөөд захиалагч талаас Монгол орны баруун бүсээс төсөлд хамрагдаж байгаа ТХГН-уудад 22ш, төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг буюу Говийн бүсээс хамрагдаж буй хамрагдаж байгаа ТХГН-уудад 13ш нийт 35 байгаль хамгаалагчийн байр барих санал ирсэн ба 2025 оны төлөвлөгөөнд тусгасан.<br><br>Дахин үйл ажиллагааны төлөвлөлийн алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Төсөлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, худалдан авах ажиллагаа болон санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлэх зарчмыг мөрдөөгүй, baccp.mn веб хуудаст ил тод байдлыг хангаагүй | Төслийн цахим хуудасанд ХШҮ-ний тайлан, төлөвлөгөөг оруулсан байдал<br>http://baccp.mn/monitoring?year=2024<br>Шилэн дансны цахим систем<br>https://shilendans.gov.mn/organization/20946?ry=2024&group=121 | Төслийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа болон худалдан авах ажиллагааны тайлан зар мэдээ зэрэг нь төслийн албан ёсны baccp.mn болон фэйсбүүк цахим хуудсанд тайлан болон мэдээлэл, пост хэлбэрээр тухай бүр тайлагнаж, ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Төслийн тайлагналтад мониторинг хийж, дутуу оруулсан тайланг нөхөн оруулж алдаа, дутагдлыг зассан.<br><br>**Тайлан мэдээлэл бүрэн орсон байдал:**<br>Төслийн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан baccp.mn цахим хуудсанд 2020-2024 оны жилийн эцэс хүртэлх 6 тайланг оруулан баталгаажуулсан Үүнд:<br><br>2021 онд - ҮА, ХШҮ-ний жилийн эцсийн тайлан<br>2022 онд - ХШҮ-ний жилийн эцсийн тайлан<br>2023 онд - ХШҮ-ний хагас болон жилийн эцсийн тайлан<br>2024 онд - ҮА, ХШҮ-ний хагас жилийн болон жилийн эцсийн тайланг тус тус тайлагнасан байна.<br>2025 онд - ХШҮ-ний төлөвлөгөө, хагас жилийн тайланг оруулж баталгаажуулсан.<br><br>Тайлан мэдээ оруулалтыг хянаж үзэхэд төсөл нь үйл ажиллагаа болон ХШҮ-ний мэдээллийг төслийн цахим хуудаст тухай бүр оруулж ажиллаж байна.<br><br>**Дараах тайланг нөхөн оруулсан:**<br><br>Төслийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор дараах тайлан мэдээг ил тод болгон нөхөж оруулсан Үүнд:<br>1. Төсөлд хийгдсэн төслийн санхүүжүүлэгч тал Германы Сэргээн босголтын банк (KfW)-ны хөндлөнгийн үнэлгээний багийн 2020-2025 онуудад ажилласан жил бүрийн тайлан, үүрэг даалгавар. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2. Худалдан авах ажиллагааны 2023 оноос бусад оны тайланг нөхөн оруулсан.<br>3. 2022-2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан<br>4. Зөвлөх үйлчилгээний тайланг тус бүр хянан нөхөн оруулсан.<br>5. 2025 онд захиалагч тал болох БОУАӨЯ-ны Хяналт үнэлгээ дотоод аудитын газраас төслийн 2022-2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын тайлан.<br>6. Зөвлөмжийн биелэлтийн тайлан.<br><br>Цаашид төслийн веб хуудсаар дамжуулан төслийн нийт үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж мэдээ, тайланг үнэн зөв, заасан хуулийн хугацаанд оруулахад хяналт тавьж ажиллана. |
| 5 | Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.2, 4.1.3 2016 оны 176 дугаар тогтоолын 13.1.9-д заасны дагуу Шилэн дансны тухай хуулийн дагуу үнэн зөв тайлагнах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй | | Санхүүгийн тайлангийн тухайд тус төслийн веб сайт нь төрийн санхүүгийн шилэн дансны системтэй шууд холбоотой бөгөөд тайлант онуудад заасан хугацаанд тайлагнаж ажилласан ч хугацаа хэтрэлттэй тайлан мэдээ олон байна.<br><br>Төслийн санхүүгийн тайлан үйл ажиллагаа нь төслийн удирдах хорооны дарга, захирал, зохицуулагч нарын гарын үсгээр давхар хянагддаг тул, дээрх албан тушаалтнуудын олон удаагийн томилгоо нь тайланг хугацаандаа системд бүртгэгдээгүй байхад нөлөөлсөн болно. Мөн хангалтгүй ажилласан төслийн санхүүгийн ажилтанд хариуцлага тооцож 2024 оны 05 дугаар сард ажлаас чөлөөлсөн.<br><br>Шилэн дансны мэдээ бүрдүүлэлтийг хянаж үзэхэд дараах тайлагналттай байна.<br><br>**2023 онд:**<br>Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарцуулалт болон гүйлгээний тайланд |

| | | | |
|---|---|---|---|
| | | | • Сар бүр тайлагнах 5 төрлийн 60 мэдээл оруулалтаас 2 удаа хугацаа хэтэрсэн, 21 удаагийн тайлан мэдээлэл оруулаагүй байна.<br>• Хагас жил тутам тайлагнах 4 төрлийн мэдээ оруулалтаас 3 удаагийн тайлан оруулаагүй байна.<br>• Жилийн эцэст тайлагнах 7 удаагийн тайлан оруулалт үүнээс 5 удаагийн тайлан хоцорсон байна.<br>**2024 онд:**<br>• Сар бүр тайлагнах 5 төрлийн 60 мэдээл оруулалтаас 8 удаагийн тайлан хугацаа хэтэрсэн байна.<br>• Хагас жил тутам тайлагнах 4 төрлийн мэдээ оруулалтаас 4 удаагийн тайлан хугацаа хэтрэлттэй байна.<br>• Жилийн эцэст тайлагнах 7 удаагийн тайлан оруулалт бүгд хугацаандаа орсон байна.<br>**2025 онд:**<br>• Сар бүр тайлагнах 5 төрлийн 60 мэдээл оруулалтаас 4 удаагийн тайлан хугацаа хэтэрсэн байна.<br>• Хагас жил тутам тайлагнах 4 төрлийн мэдээ оруулалт бүгд хугацаандаа тайлагнасан байна.<br>• Жилийн эцэст тайлагнах 7 удаагийн тайлан оруулалт үүнээс 1 удаагийн тайлан хугацаандаа орсон байна. 6 тайлан оруулалт хугацаа болоогүй байна.<br><br>Төслийн санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд холбогдох журмын дагуу шилэн данс, Удирдлагын мэдээллийн систем (УМС), харьяа яамдуудад танилцуулан ажилласан. Санхүүгийн тайлан тооцоо нь төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө хугацаандаа баталгаажих, мөн захиалагч талуудын гарын үсгийн баталгаа зэргээс хамаарч ихээхэн хугацаа алддаг тул энэхүү тайлан мэдээг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хугацаанд нь баталгаажуулан хүргүүлэхэд төслийн удирдлага, захирал бусад талууд анхаарч ажиллах шаардлагатай байна.<br><br>Худалдан авах үйл ажиллагааны тухайд төлөвлөгөө, сарын бүрийн 25-ны мэдээ тайлан Шилэн дансны тухай хуулийн дагуу үнэн зөв тайлагнах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.<br><br>Цаашид санхүүгийн үйл ажиллагааны тайлан, шилэн дансны журмыг мөрдөж ажиллана. |
| 6 | Төслийн хүрээнд авсан тоног, төхөөрөмж, үндсэн хөрөнгийн бүртгэл хяналт сул | | ТХН нь төслийн зөвлөх багтай хамтран жил бүр төслөөс өгсөн хөрөнгө оруулалт тэдгээрийн ашиглалтад хяналт-мониторинг хийх зорилготой орон нутагт ажиллах төлөвлөгөөг баталгаажуулан, тайлагнан ажилладаг.<br>Өнгөрсөн 5 жилийн хугацаанд төслийн хүрээнд баригдаж буй барилга, техник, тоног төхөөрөмжийн бүртгэл хяналтын чиглэлээр нийт 12 удаагийн хяналт-мониторингийн ажлыг БОАЖЯ-ны (хуучин нэрээр) санхүү хөрөнгө оруулалтын газар, хэлтсийн мэргэжилтэн, ТХБНУГ-ын (хуучин нэрээр) ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нартай хамтран хийж, тайлагнаж ажилласан.<br>Төслийн орон нутаг хариуцсан ажилтан нар тухай бүр ажлын уялдуулан хяналт-мониторингийн ажлыг тогтмол хийж, ТХН, ЗБ-т тайлагнаж ажилладаг.<br><br>Түүнчлэн төслийн санхүүжүүлэгч байгууллага Германы Сэргээн Босголтын (KfW) банкнаас 2021-2024 онуудад жил бүр төсөл хэрэгжиж буй газар нутгуудад төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт үнэлгээ, хөрөнгө бүртгэл, ашиглалтад мониторинг хийж ажилладаг. Энэхүү хяналт-мониторинг үр дүнд суурилсан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой зөвлөмж өгч тухай бүр Үнэлгээний тэмдэглэл (MoM) үйлдэж Германы Сэргээн босголтын (KfW) банкны төслийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | менежер, Төслийн Удирдах хорооны дарга, Төслийн захирал нар гарын үсэг зурж баталгаажуулж ажилладаг.<br><br>Төслийн хүрээнд байгаль орчны байгууллагуудад олгосон хөрөнгө бүртгэл, ашиглалтад хийсэн хяналт, мониторингийн үр дүнд үндэслэн 2024 онд төслөөс олгосон хөрөнгүүдийг бүртгэх тухай албан хүсэлтийг БОАЖЯ (хуучны нэршил) руу 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 24/033, 24/034 мөн 2024 оны 10 дугаар сард тодруулах албан тоотыг тус тус хүргүүлж байсан. Энэ ажлын хүрээнд төслийн хүрээнд хөрөнгө оруулалт хийгдсэн ч өмчид бүртгэгдээгүй байсан 2021-2024 онд шинээр үүссэн 11.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5692 ширхэг эд хөрөнгийг нэгтгэн хөрөнгө, орлогод бүртгэх тухай БОУАӨЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 09/2577 дугаартай албан чиглэл авч, төслийн хүрээнд санхүүжилт авсан нийт 147 байгууллагад хүргүүлэн тайлан мэдээг нэгтгэсэн.<br><br>Мөн 2025 оны төслийн ХШҮ-ний төлөвлөгөөнд тусгагдсан 3 чиглэлийн дагуу төслийн хүрээнд олгосон хөрөнгө оруулалтын ашиглалт, хөрөнгө бүртгэл, тогтвортой байдлыг хэрхэн хангаж буй хяналт-мониторинг хийж ажиллахаар төлөвлөсөн болно. Хяналт мониторингийн ажлын хүрээнд 9 аймгийн 17 УТХГ, 9 БОГ, 11 ЕБС, 4 УЦУОШГ, 4 СГЗ, 4 Ойн анги, 8 Эрүүл мэндийн төв, 12 Хүлэмж ашиглагч, 25 Усалгааны төхөөрөмж ашиглагч нарын төслийн хүрээнд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх, ашиглалтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан. Орон нутгийн хяналт мониторинг, хөрөнгө бүртгэл, ашиглалтын төлөв байдал, хөрөнгө оруулалтын үр дүнг тайлан илтгэх хуудас, нэгдсэн тайлангаар тайлагнасан. Мөн хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, үр дүнг нэгтгэсэн байдлаар төслийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | захирал, санхүүжүүлэгч талуудад 09 дүгээр сар болон 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд тайлагнасан.<br><br>Мөн төслийн хөрөнгө оруулалтын үр дүн, биологийн олон янз байдлыг хамгаалахад үзүүлсэн дам нөлөөлийг үнэлэх зорилгоор дижитал мониторинг системд суурилсан үр дүнг үнэлэх судалгаа, үнэлгээг хийсэн. Нийт үр дүнг төслийн үр дүнгийн мониторинг матрикс болон POWER BI системд суурилан харуулахаар бэлтгэсэн болно.<br>Төслийн удирдах хороо болон 2025 оны жилийн эцсийн тайланд бүх үр дүнг тусгаж тайлагнана. |
| 7 | Төслийн хүрээнд БОУАӨСайдын эрхлэх хүрээнд хамаарахгүй байгууллагуудад өгсөн (сургууль, эмнэлэг, аймгийн БОГ, Ойн анги, онцгой байдлын газар) тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгийн тооллого хийгдэж байгаагүй, ашиглалт элэгдэл хорогдол үр нөлөөг судлаагүй, үнэлгээ мониторинг хийгээгүй | Төслийн цахим хуудас дах тайлан, мэдээлэл http://baccp.mn/project/detail_2 | Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь жил бүрийн ХШҮ-ны орон нутагт хяналтаар ажиллах төлөвлөгөө батлуулж, төслийн хүрээнд олгосон нийт хөрөнгийн бүртгэл тооцоог орон нутаг хариуцсан ажилтан, төслийн зөвлөх багийн орон нутгийн салбарууд хамтран жил бүр хийж, тайлан мэдээг санхүүжүүлэгч талд хүргүүлэн ажилладаг. Төсөл хэрэгжих хугацааны 2020-2024 онуудад нийт 12 удаагийн орон нутгийн хяналт-мониторингийг чиглэл бүрд хяналт тавин ажилласан.<br><br>Төслийн зүгээс хийсэн хяналт-мониторинг үр дүнд үндэслэн 2024 онд хөрөнгө бүртгэх тухай албан хүсэлтийг захиалагч, хүлээн авагч байгууллага руу 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 24/033, 24/034, 2024 оны 10 дугаар сард тодруулах албан тоотыг тус тус хүргүүлж байсан. Энэ ажлын хүрээнд нийт хөрөнгө орлогод бүртгээгүй үлдсэн тоног, төхөөрөмжийг хөрөнгө, орлогод бүртгэх, тухай БОУАӨЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 09/2577 дугаартай албан бичгийг төслийн хүрээнд санхүүжилт нийт 147 байгууллагад хүргүүлэн тайлан мэдээг нэгтгэсэн.<br><br>Төслийн хүрээнд БОУАӨСайдын эрхлэх хүрээнд хамаарахгүй байгууллагуудад өгсөн (сургууль, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | эмнэлэг, аймгийн БОГ, Ойн анги, онцгой байдлын газар) хөрөнгө бүртгэл, хяналтыг 2020-2024 онуудад дараах байдлаар хийсэн Үүнд:<br><br>1. *Зорилтот 18 УТХГ-ын орчны бүсийн 75 ЕБС – Эко-танхимын ашиглалт*:<br>Төслийн ажилтнууд орон нутагт ажиллах үеэр Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн, Дөргөн, Говь-алтай аймгийн Баян уул, Жаргалан, Хөхморьт, Баян-өлгий аймгийн Дэлүүн, Баяннуур, Сагсай, Дундговь аймгийн Гурвансайхан сумдын сургуулиудад ажилласан. Хяналт мониторингоор ажиллах үед гарсан зөрчлийг арилгуулж, цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөмж өгсөн. УТХГ-ын хамгаалалтын захиргааны орчны бүсийн сумд тул мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарыг харьяа сургуулиудтайгаа сайтар хамтарч ажиллах, үйл ажиллагаа зохион байгуулах төлөвлөгөөг гарган ажиллахыг зөвлөж, үр дүнг тайлагнан ажилласан.<br>2. *5 аймгийн сум дундын ой анги – 7ш трактор:*<br>Орон нутгийн ажилтнууд ой ангиудтай байнгын холбоотой ажиллаж байна. Чанарын баталгаат хугацаанд эвдрэл гараагүй. Ховдын ой анги нүх ухагчийн төхөөрөмжийг өөрсдийн буруутай ажиллагаанаас гэмтээснийг гүйцэтгэгч компанитай холбож өгч Сум дундын ойн анги өөрсийн төсвөөр худалдаж авч техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан.<br>3. *Төсөл хэрэгжиж буй 7 аймгийн 17 суманд түргэн тусламжийн тоноглогдсон автомашин:*<br>Түргэн тусламжийн автомашины ашиглалтад хяналт тавьж ажилладаг. Тус хяналт-мониторингийн үеэр өвчтөн тээвэрлэх хэсгийн халаагуурын хүчин чадал муу байгаа санал хүсэлтийн дагуу Ховд аймгийн 3 Эрүүл мэндийн төв (ЭМТ)-өөс тодруулж, гүйцэтгэгчид мэдэгдсэнээр энэ хүрээнд 17 сумын ЭМТ-үүдэд бүгдэд хяналт хийгдэж, нийт 17 автомашины өвчтөн тээвэрлэх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хэсэгт нэмэлт халаагуур суурилуулан халаалтын асуудлыг чанарын баталгааны хүрээнд гүйцэтгэгчээр бүрэн шийдвэрлүүлсэн. Мөн төслийн хүрээнд олгосон машины ашиглалт сар, улирлын ашиглалт, дуудлага бүртгэлд анализ хийж үр дүнг санхүүжүүлэгч талд тайлагнахаар бэлтгэсэн.<br><br>4. *Орчны бүсийн сумдын иргэдийн амьжиргаа дэмжих хүрээнд олгосон хүлэмж, услалтын системийг 5 аймгийн 70ш бичил төсөл:*<br>Хяналтыг орон нутагт ажиллах үеэр болон цахимаар хийж ажилласан. Энэ хүрээнд Говь-Алтай аймгийн Бугат, Ховд аймгийн Жаргалант суманд олгосон хүлэмжийн ашиглалт муу, 3 талт гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас тухайн сумдын засаг даргын тамгын газар (ЗДТГ), харьяа УТХГ-ын хамгаалалтын захиргааны хамтарсан ажлын хэсгийн шийдвэрийн дагуу дараагийн гэрээлэгчид шилжүүлэн өгсөн.<br><br>Энэ ажлын хүрээнд төслийн 2025 оны ХШҮ-ний төлөвлөгөөний дагуу 3 чиглэлд зохион байгуулж ажилласан. Хяналт мониторингийн ажлын хүрээнд 9 аймгийн 17 УТХГ, 9 БОГ, 11 ЕБС, 4 УЦУОШГ, 4 СГЗ, 4 Ойн анги, 8 Эрүүл мэндийн төв, 12 Хүлэмж ашиглагч, 25 Усалгааны төхөөрөмж ашиглагч нарын төслийн хүрээнд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх, ашиглалтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.<br><br>Төслийн хөрөнгө оруулалтын үр дүн, биологийн олон янз байдлыг хамгаалахад үзүүлсэн дам нөлөөллийг үнэлэх зорилгоор дижитал мониторинг системд суурилсан үр дүнг үнэлэх судалгаа, үнэлгээг хийсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | | | Нийт үр дүнг төслийн үр дүнгийн мониторинг матрикс болон POWER BI системд суурилан харуулахаар бэлтгэсэн болно. |
| 8 | Төслийн хүрээнд нийт 27.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хөрөнгө зарцуулахаас 2024 оны эцсийн байдлаар 10.7 сая евро зарцуулсан ба худалдан авсан бараа, ажил үйлчилгээг хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаанд тооцож үзвэл бүгд 2-10 жилд элэгдэж дуусахаар байна. | | Төслийн зөвлөх баг, төслийн зорилтот бүс нутагт буй ТХГ, кластерт багтсан байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөнд туссан болон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тоног төхөөрөмж, үндсэн судалгааны болон хээрийн багаж хэрэгслийн хэрэгцээ шаардлагын судалгаа, санал хүсэлтийг авч түүнд үндэслэн шаардлагатай хувцас, тоног төхөөрөмж, барилга, зөвлөх үйлчилгээг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг. Энэ тухайн байгууллагын менежментэд туссан бараа, тоног төхөөрөмжийн хэрэгцээнээс хамаарах бөгөөд хөрөнгийн төрөл, зориулалтаас хамаарч ашиглах хугацаа нь өөр байна. Төслийн хүрээнд олгосон бараа, тоног төхөөрөмж нь мөн тухайн байгууллагын өмч хамгаалах комисс, актын бүртгэлд хамаарах тул хэдэн жил ашиглахыг тухай байгууллага шийдвэрлэдэг.<br><br>Төслийн хүрээнд 2025 онд 3 чиглэлд хөрөнгө бүртгэл, ашиглалтад мониторинг хийсэн. Үүнд төслийн нэгдүгээр үе шатанд олгосон оффис сандал ширээ, хэрэгсэл болон зарим хээрийн судалгааны багаж хэрэгслийг хугацаа сунган ашигласан байна. Хувцас хэрэгсэл болон зарим хээрийн нөхцөлд ашигладаг цөөн хэрэгслийг акталсан байна.<br><br>Тус хөрөнгө ашиглалт, акталсан зэрэг бүртгэл тайланг хамгаалалтын захиргаадын цахим систем болон төслийн хяналт мониторингийн тайлангаас үзэж болно. |
| 9 | Засгийн газрын 2016 оны 176 дугаарын тогтоолын хавсралтаар баталсан "Гадаад тусламж авах, зарцуулах Удирдах, бүртгэх тайлагнах журам"-ын 13.1.10-д заасны дагуу Удирдлагын мэдээллийн | | Төслийн үйл ажиллагааны тайлан мэдээг Удирдлагын мэдээллийн системд (УМС) цаг хугацаандаа, бүрэн тайлагнан ажилласан, гарсан зөрчилгүй болно. Ажилтан бүр тайлан мэдээллийг бүрэн оруулсан байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | https://odamis.mof.gov.mn цахим системд мэдээллийг бүрэн оруулж ажиллаагүй | | Төслийн хяналт үнэлгээ мониторинг хариуцсан ажилтны УМС-д тайлагнасан байдалд хяналт тавьж ажиллахад 2020-2025 онуудад нийт 9 төрлийн 57 үндсэн мэдээ, тайланг оруулсан Үүнд:<br><br>• Тусгай гэрээ - 11 удаа ( Англи,Герман болон Монгол гурван орны хэлээр)<br>• Бодлогын баримт бичиг - 2 удаа<br>• Санамж бичиг - 3 удаа (KfW банкны хөндлөнгийн үнэлгээ)<br>• Удирдах хорооны шийдвэр - 5 удаа<br>• Төслийн танилцуулга - 3 удаа<br>• Үйл ажиллагааны төлөвлөгөө - 8 удаа (2 хэл дээр)<br>• ХАА-ний төлөвлөгөө - 7 удаа (2 англи, монгол хэл дээр)<br>• Үйл ажиллагааны тайлан - 10удаа (хагас болон бүтэн жилээр)<br>• Хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан - 6 удаа (хагас болон бүтэн жилээр) оруулсан байна.<br>• Бусад холбогдох тушаал - 2 удаа<br><br>УМС-д дутуу орсон тайлан мэдээлэл байхгүй болно. Тиймээс цаашид мэдээ, тайланг тухай бүр баталгаажуулсан оруулж ажиллана. |
| 10 | Засгийн газрын 2016 оны 176 дугаарын тогтоолын хавсралтаар баталсан "Гадаад тусламж авах, зарцуулах Удирдах, бүртгэх тайлагнах журам"-ын 21.5, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бараа, ажил ажил үйлчилгээг сургалтын зардал тус бүрийн төсвийг ТУХ-оор хэлэлцүүлэхээс өмнө гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжээр хянуулсан байх заалтын | | Жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Төслийн удирдах хорооны гишүүд, захиалагч болон санхүүжүүлэгч талд танилцуулж зөвшөөрөл авч баталгаажуулдаг. Төслийн удирдах хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга болон мэргэжилтэн нар багтдаг болно.<br><br>Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаатай худалдан авах төлөвлөгөөг боловсруулдаг тул тус төлөвлөгөөнд сангийн яамнаас үйл ажиллагааны |

| | | | |
|---|---|---|---|
| | дагуу 2022-2024 оны төлөвлөгөөнд Сангийн яамнаас санал аваагүй. | | төлөвлөгөөнд ирүүлсэн санал, зөвшөөрөлд үндэслэдэг учир нэмэлтээр санал аваагүй болно. |
| 11 | Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх Үйлчилгээ, Ажил, Үйлдвэрийн Байгууламж, Барааны болон Зөвлөх бус үйлчилгээ Худалдан Авах ажиллагааны Удирдамжийн 2.1.5-д заасны дагуу Гэрээ шууд байгуулах журам, ТНБД 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсны дагуу Төлөвлөгөөнд батлагдсан 20,000 евро хүртэлх үнийн дүн бүхий ажил, бараа, зөвлөх үйлчилгээг захиалагч тухайн чиглэлээр туршлагатай эрх бүхий 3 байгууллагын нэрсийг үнэлгээний хороонд танилцуулж, тус 3 байгууллагад оролцох урилга хүргүүлээд үүнээс 1 байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулна гэж заасныг мөрдөөгүй. | Тендер зохион байгуулах журам - https://baccp.mn/uploads/52e70f0c4781753bc1114f3dd97f3eb6.pdf Төслийн худалдан авах ажиллагааны удирдамж- http://baccp.mn/procedure/detail/4 | Санхүүжүүлэгч тал Германы Сэргээн Босголтын зээлийн (KfW) банктай байгуулсан тусгай гэрээнд “Шууд байгуулах” боломж бүхий хэд хэдэн нөхцөл, шаардлагуудтай. Энэ нь тус гэрээний 2.1.5 Гэрээ Шууд Байгуулах Журам Гэрээ шууд байгуулах журмыг хэрэглэх тохиолдолд, ТХА-ын боловсруулсан ажлын тодорхойлолт, шаардлага, эсхүл ажлын даалгавар зэрэгт үндэслэн шалгуур хангаж урьдчилан сонгогдсон цорын ганц Этгээдийг Тендер ирүүлэхийг урина. ТХА нь тухайн Санал болон Гэрээний шаардлагад нийцсэн болон өрсөлдөхүйц байгааг баталгаажуулж, сонгогдсон Тендерт оролцогчийг шалгуур хангасан болохыг батлах үүрэгтэй юм. Төслийн хүрээнд үйл ажиллагаанд тусгагдсан жижиг төсөл, тендер арга хэмжээг түргэн шуурхай, журмын дагуу зохион байгуулах зорилгоор санхүүжүүлэгч талаас зөвшөөрөл авч захиалагч талтай зөвшилцөж БОАЖЯ-ны (хуучны нэршил) Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Гэрээ шууд байгуулах” Удирдамжид тусгагдсан эрх бүхий ажлуудыг журмын дагуу гэрээ байгуулан ажилласан болно. Гэрээ шууд байгуулах ажлын тайлан, гэрээ, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл зэргийг захиалагч болон санхүүжүүлэгч талд тухай бүр тайлагнан ажилласан болно. Төслийн хүрээнд хийгдсэн Шууд гэрээ байгуулах ажлууд нь байгаль хамгаалах, судалгааны чиглэлийн ажлууд болно. Тус ажлуудыг мэргэжлийн судалгааны төв байгууллага, их сургуультай хамтран хийгдсэн ажлууд болно.<br><br>Цаашид Шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах тохиолдолд талуудад мэдээлэл, журмыг танилцуулан ажиллана. |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Түншлэгч Улсуудтай хийх Санхүүгийн Хамтын Ажиллагааны хүрээнд Зөвлөх Үйлчилгээ, Ажил, Үйлдвэрийн Байгууламж, Барааны болон Зөвлөх бус Үйлчилгээ Худалдан Авах Ажиллагааны Удирдамжийн 2.4.10-д заасны дагуу Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа мониторингийн сургалт зохион байгуулах тендерийг 2024.06.21-ний өдрийн 10 цагт нээнэ гэж www.tender.gov.mn хаягт зарласан ч, 6 хоногийн өмнө 1 хоногийн өмнө 2 удаа сунгахдаа Тендерийн үнэлгээний хорооны нарий бичгийн дарга биш хүн нь албан бичгээр хандаагүй, мэйл хаягаар зар хүргүүлсэн байна. | | Төслийн худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж ажиллаагүй тухайн үйлдэлд төсөл хэрэгжүүлэгч нэгж цаашид анхааран ажиллах болно. Төслийн худалдан авах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулна. |
| 13 | Баруун бүсийн болон сонгогдсон ТХНГ-ийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах тендерийн ажлын даалгаврыг 2 удаа батлуулж, анх батлагдсан ажлын даалгаварт 215 ширхэг мотоцикл байсныг 200 ширхэг болгосон шийдвэрийн баримт байхгүй. | | Төслийн зөвлөх баг УТХГ-уудад нийлүүлэх мотоциклийн хэрэгцээ шаардлын судалгааг 2022 оноос эхлэн авч, түүнд үндэслэн ажлын даалгавар, тоо ширхэг, хуваарийг хийж талуудад танилцуулж баталгаажуулсан. Гэвч Өмнөговь аймгийн ЗДТГ-аас Говийн бага ДЦГ-т 19ш, Говь гурван сайхны БЦГ-ын хамгаалалтын захиргаадын 23ш мотоцикл 2023 оны 05 дугаар сард өгсөн учраас мотоциклын хуваарилалтыг дахин шинэчлэх шаардлага гарсан. Энэ талаар захиалагч талд танилцуулж БОАЖЯ-ны (хуучны нэрээр) санхүүгийн хэлтсээс хөрөнгийн бүртгэлийн судалгаа мэдээлэл авч, хамгаалалтын захиргаадын бүтэц орон тооны тушаалтай харьцуулж, шинээр байгуулагдсан хамгаалалтын захиргаадыг нэмж дахин хуваарилалт хийсэн. Шинэчилсэн хуваарилалтыг яамны холбогдох бүх талуудад танилцуулж, санал авч, ажлын даалгаврын хавсралтаар батлуулсан. Тус ажлын даалгаварт өөрчлөлт орж, хуваарийг дахин шинэчлэх ажлын талаар зөвлөх баг, БОУАӨЯ-ны (хуучны нэрээр) Хяналт үнэлгээ дотоод аудитын газрын дарга Т. Гоцбаяр, төслийн захирал буюу ТХБНБЗГ-ын дарга А.Энхжаргал, зохицуулагч |

| | | | |
|---|---|---|---|
| | | | М.Болдбаяр болон бусад бүх талуудад албан мэйлээр болон тухайлсан уулзалтуудад танилцуулсан.<br>- Захиалагч талд – 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн албан и-мэйл (enkhjargal.mrtd@gmail.com )<br>- Захиалагч талд – 2023.06.26-ны өдрийн албан и-мэйл (enkhjargal.mrtd@gmail.com)<br>- Захиалагч талд – 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн албан и-мэйл ( gotsbayar@met.gov.mn).<br><br>Цаашид ажлын даалгаврын баталгаажуулалт, түүнд өөрчлөлт орвол тухай бүрд талуудад танилцуулан албажуулан ажиллана. |
| 14 | Түншлэгч улсуудтай хийх Хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх Үйлчилгээ, Ажил, Үйлдвэрийн Байгууламж, Барааны болон Зөвлөх бус үйлчилгээ Худалдан авах Ажиллагааны Удирдамжийн 2.6-д заасны дагуу Баруун бүсийн болон сонгогдсон ТХНГ-ийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах тендерт гомдол гарсныг Худалдан авах Ажиллагаанд Холбогдох Гомдол, Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/100 дугаар тушаалаар байгуулагдсан гомдол хянах ажлын хэсгээр шалгуулаагүй. | | Тус гомдлын талаар 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 03-02/1108 дугаартай Тендер түдгэлзүүлэх тухай албан бичиг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлсэн.<br>2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 03-02/1134 дугаартай Тендерийн баримт бичиг хянасан тухай албан бичиг “Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө” газраас төслийн нэгжид ирүүлсэн. Тус албан бичгүүдийн албан бус орчуулгыг санхүүжүүлэгч болон эх хувийг захиалагч талд танилцуулсан. Мөн төслийн зөвлөх баг болон төсөл хэрэгжүүлэгч нэгжээс тус ажлын хамтарсан хурлыг захиалагч талтай хамтран удаа дараа зохион байгуулж ажилласан. Энэ тендерийн гомдлын мэдээллийг захиалагч талд, холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>Төслийн зөвлөх баг, худалдан авалт хариуцсан ажилт нарын хооронд албан мэйлээр харилцсан болно. Захиалагч талд албан мэйл ( gotsbayar@met.gov.mn).<br><br>Цаашид төслийн үйл ажиллагаа, тендер зарлах, шалгаруулалттай холбоотой гомдол, санал мэдээллийг баримтжуулах, баталгаажуулж тухай бүрд талуудад танилцуулан ажиллана. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | |
| 15 | Тендерийн батлагдсан ажлын даалгаврыг www.tender.gov.mn-д байршуулахдаа үнэлгээний хорооны гишүүдийн гишүүдийн нэрстэйгээр байршуулсан 5 тендер байна. | Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд орсон мэдээлэл - https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1666404642793 https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1657042568138 https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1689408759618 https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1677470753397 https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1685680630553 | Төслөөс зарласан тендерийн ажлын даалгаврыг оруулахдаа ажлын хэсэг, үнэлгээний хорооны гишүүдийн баталгаажуулсан нэрстэй хамт оруулсан зөрчил дээрх 5 тендерт илэрсэн. ТХН-ийн зүгээс тус алдааг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллана. Мөн дээрх 5 тендерийн зар, ажлын даалгаврыг үнэлгээний хорооны гишүүдийн нэрстэй байршуулсан ажилтанд хариуцлага тооцсон болно. |
| 16 | Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх Үйлчилгээ, Ажил, Үйлдвэрийн Байгууламж, Барааны болон Зөвлөх бус үйлчилгээ Худалдан Авах ажиллагааны Удирдамжийн 1.2.1 "Үндсэн зарчим болох Өргөдөл гаргагч / тендерт оролцогч нарыг Тендерийн Ажиллагаанд оролцох ижил тэнцүү боломжоор хангана", Өргөдөл гаргагч/ тендерт оролцогч нартай тэгш бус харилцахыг хориглоно гэж заасныг баримтлаагүй. “Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж Монгол Алтайн нурууны өндрийн градиент дагуух ургамлын шилжилтийн судалгаа” сонгон шалгаруулалтад багийн ахлагчаас шинжлэх ухааны доктор (Ph.D) зэрэгтэй байх зэрэг ялгаварлан гадуурхсан шалгуур тавьсан. ялангуяа уулын ургамлын судалгаанд - энэ нь тендерт оролцогчдод тэгш боломж олгох зарчмыг зөрчиж байна. | Монгол орны ургамлын аймгийн бүс бүслүүрийн ангилал - https://mn.wikipedia.org/wiki/%D0%A3%D1%80%D0%B3%D0%B0%D0%BC%D0%B0%D0%BB_%D0%BE%D0%B9_%D1%85%D0%B0%D0%BC%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BB%D0%B0%D0%BB | Монгол орны ургамалжлын бүс бүслүүр нь 6 ангилалд хуваагддаг ба бүслүүр бүр дотроо 2-4 дэд бүслүүрт хуваагддаг. Төслийн зорилтот Өндөр уулын бүслүүр нь дотроо мөн 4 дэд бүслүүрт хуваагддаг. Ургамлын аймгийн судалгаа нь нарийн төвөгтэй бөгөөд тухайн бүслүүрийн чиглэлээр мэргэшээгүй бол ангилал зүй, хөдлөл зүйн судалгаа хийхэд хүндрэлтэй. Тиймээс төсөл, тендерийн ажлын гол зорилго нь Уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч Монгол алтайн уулсын өндрийн бүс бүслүүрийн дагуу ургамлын бүлгэмдлийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлэх судалгааны ажил юм. Тухайн нарийн мэргэжлийн заалт шалгуур нь тус судалгааны ажлыг илүү мэргэжлийн түвшинд хийгдэх боломжийг хангах зорилготой юм. Иймд тухайн судалгааг доктор, зэрэгтэй туршлагатай мэргэжлийн судлаач ахлах нөхцөлийг тавьсан болно. Энэ нь тендерт оролцогчдод тэгш боломж олгох зарчмыг зөрчсөн гэж үзэхгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Энэхүү шалгуурыг зөвхөн багийн ахлагчид тавьсан бөгөөд бусад ургамал судлаач, магистр болон бакалаврын түвшний оюутан нар ажиллах боломжийг нээлттэй үлдээсэн болно. |

| Төслийн хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны хүрээнд өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн мэдээлэл | | | |
|---|---|---|---|
| **№** | **Хяналт-шинжилгээний ажлаар өгсөн зөвлөмж** | **Хавсралт** | **Биелэлт, мэдээлэл** |
| 1 | Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ийн 7.2.2-д Төсөл арга хэмжээг дунд хугацаанд төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх, төслийн хэрэгжилтийг уг төлөвлөгөөний хүрээнд үнэлэх 2020-2027 онд хэрэгжүүлэх, төслийн хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх | Төслийн 2025-2026 оны Стратегийн төлөвлөгөө - https://docs.google.com/document/d/1mrhBIUFvHcgQ3haaYigASWQN9_8JeQN8/edit?usp=drive_link&ouid=113679666933298618261&rtpof=true&sd=true | 2024 оны 10 дугаар сард төслийн санхүүжүүлэгч тал болох Германы Сэргээн Босголтын зээлийн банк (KfW)-ны мониторинг үнэлгээ хийгдэж, төслийн хэрэгжилтийн сүүлийн 2 жилийн хугацаанд мөрдөж ажиллах чиглэл өгсний дагуу богино хугацаанд буюу 2025-2026 онуудад хэрэгжих Стратегийн Бодлого төлөвлөгөө (Strategic Framework) боловсруулж, БОУАӨЯ ба санхүүжүүлэгч талаар баталгаажуулсан. Энэхүү Стратегийн Бодлогод уялдуулан 2025, 2026 оны үйл ажиллагаа төлөвлөсөн болно. |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Төрийн хэмнэлтийн тухай 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь хэсэг, ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ийн 21.2, Улсын Их хурлын 2022 оны 72 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 1.3-д заасныг баримтлан 2025 оны төлөвлөгөөг баталж мөрдөх | | Зөвлөмжид дурдсан хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг мөрдөж ажилласан.<br>Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Төрийн хэмнэлтийн тухай 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалтын дагуу энэ жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан барилга, байгаль хамгаалагчийн байрны техник, эдийн засгийн үндэслэл баталгаажуулж, зураг төсвийг нь 2024-2025 онуудын он дамнасан үйл ажиллагааг төлөвлөж зураг төслийг захиалагч болон Барилга хөгжлийн төвд хүргүүлж, мэргэжлийн зөвлөлөөр зураг, төсвийг хэлэлцүүлэн баталгаажуулсан. Тус барилгуудыг барих газрын зөвшөөрлийг орон нутаг, хүлээн авагч талуудтай хэлэлцэж шийдвэрлэсэн.<br><br>2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг мөн журмын дагуу боловсруулсан. Төлөвлөгөөний төслийг захиалагч тал болох БОУАӨЯ-ны холбогдох газар, хэлтсүүдийн саналыг тусгаж санхүүжүүлэгч байгууллага (KfW)-д танилцуулан ажиллаж байна. |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн дагуу үнэн зөв тайлагнах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах | https://shilendans.gov.mn/organization/20946?ry=2025&group=121 | Төслийн веб хуудсаар дамжуулан шилэн дансны мэдээллийг ил тод, үнэн зөв байдлыг хангаж ажиллах зорилгоор 2023-2025 оны шилэн дансны мэдээ, тайлан бүртгэлийг хянаж, ТХН-ийн хариуцсан ажилтан нарт танилцуулсан.<br><br>Төслийн 2025 оны үйл ажиллагаанд санхүүгийн тайлан, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг улирал, хагас жил, бүтэн жилээр гарган тайлагнаж, ил тод байдлыг хангаж ажилласан. |
| 4 | Удирдлагын мэдээллийн https://odamis.mof.gov.mn цахим системд мэдээллийг бүрэн оруулж ажиллах. | https://odamis.mof.gov.mn/mdobject/dataview/1583295320606173?mmid=1590131997043742&mid=1590131997043742 | Төслийн үйл ажиллагааны тайлан мэдээг УМС-д тайлагнасан байдалд хяналт тавьж ажиллахад 2020 - 2025 онуудад нийт 9 төрлийн 57 мэдээг оруулсан байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Тус хөндлөнгийн үнэлгээ хийгдсэнээс хойш 2025 онд төслийн үйл ажиллагаатай холбоотой 8 төрлийн 34 мэдээ, тайланг тухай бүр баталгаажуулан оруулж, сар, улирал, жилийн тайланг бүрд мэдээ бүрдүүлэлтийг тайлагнан ажилласан болно. |
| 5 | "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл"-ийн нэгжид өгсөн дүгнэлтийн дагуу цаашид үйл ажиллагааг сайжруулах талаар дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах | | Төслийн үйл ажиллагааны 2022-2024 оны үйл ажиллагаанд хийсэн Хяналт-шинжилгээ үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгах, дахин зөрчил үүсгэхгүй байх зорилгоор төслийн захирал, захиалагч тал болон санхүүжүүлэгч талуудад танилцуулсан. Үйл ажиллагааг сайжруулах дотоод зохион байгуулалтын арга хэмжээг иргүүлсэн чиглэлийн дагуу хийж ажилласан болно. |

| **Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төслийн 2022-2024 оны үйл ажиллагаанд төсөл хэрэгжүүлэх нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмж**<br>(Худалдан авах ажиллагааны төлөвлөлт) | | | |
|---|---|---|---|
| **№** | **Хяналт-шинжилгээний ажлаар өгсөн зөвлөмж** | **Хавсралт** | **Зөвлөмжийн биелэлт** |
| 1 | Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх Үйлчилгээ, Ажил Үйлдвэрийн байгууламж, Барааны болон Зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамжийн 5.1-д заасан "KfW-ийн зөвшөөрлийг урьдчилан авсан бол ТХА нь худалдан авах ажиллагааны өөрийн дотоод дүрэм, журмыг баримталж болно" "ТХА нь тухайн төсөлд тусгайлан зориулж худалдан авах ажиллагааны журмыг боловсруулж болох бөгөөд тухайн журмаар Зөвлөх үйлчилгээ, | Тендер зохион байгуулах журам - https://baccp.mn/uploads/52e70f0c4781753bc1114f3dd97f3eb6.pdf<br>Төслийн худалдан авах ажиллагааны удирдамж- http://baccp.mn/procedure/detail/4 | Төслийн худалдан авах ажиллагааны хувьд санхүүжүүлэгч байгууллагатай хийсэн тусгай гэрээний дагуу ажилладаг. Зөвлөмжийн дагуу цаашид худалдан авах үйл ажиллагааг ил тод, ойлгомжтой зохион байгуулах зорилгоор<br>төрийн худалдан авах ажиллагааны цахим системд (tender.gov.mn) санхүүжүүлэгч талын (KfW) хөгжүүлэлтийг хийх гэрээг гүйцэтгэгч мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажилласан. Цаашид мөн худалдан авалтын үйл ажиллагааг |

| | | | |
|---|---|---|---|
| | Ажил, Бараа, Үйлдвэрийн байгууламж, болон Зөвлөх бус үйлчилгээний худалдан авах ажиллагаанд хэрэглэх журмыг тодорхойлно" гэж заасны дагуу салаа, хоёрдмол утгаар тайлбарлаагүй, Монгол улсад мөрдөх худалдан авах ажиллагааны журам баталж мөрдүүлэх. | | ойлгомжтой, нээлттэй, ил тод байдлын ханган ажиллана.<br><br>Төслийн худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой тайлбарлах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нэгжээс 2023 онд талуудад танилцуулагдаж баталгаажсан төслөөс зарлаж буй тендерийн баримт бичиг тэдгээрийн бүрдэл, онцлог ялгааг харуулсан мэдээллийг төслийн веб хуудсанд байршуулсан. Тус баримт бичгийн бүрдэл, журмыг мөрдөж ажилладаг учир дахин Монгол улсад мөрдөх худалдан авах ажиллагааны журам батлах шаардлагагүй гэж үзэж байна.<br>Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс захиалагч талтай хамтран Худалдан авах ажиллагааг ил тод, маргаангүй, хурдан шуурхай явуулах зорилгоор хэд хэдэн санхүүжүүлэгч талын зөвшөөрлийн дагуу хэд хэдэн удирдамжийг боловсруулан баталгаажуулсан Үүнд:<br>1. 2021 онд *Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөхийн бус үйлчилгээний худалдан авах ажиллагааны удирдамж*,<br>2. БОАЖЯ-ны (хуучны нэрээр) Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан "Гэрээ шууд байгуулах" Удирдамж,<br>3. БОАЖЯ-ны (хуучны нэрээр) Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан "Хязгаарлагдмал тендер"-ийг зохион байгуулах Удирдамж, |
| 2 | Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, болон Зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамжийн 2.6 Худалдан авах ажиллагаанд | Төслийн худалдан авах ажиллагааны удирдамж- http://baccp.mn/procedure/detail/4 | Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь худалдан авах ажиллагааг ил тод, шударга зохион байгуулах зорилгоор захиалагч тал болон Сангийн яамны төлөөллүүд оруулан Худалдан авах Ажиллагаанд Холбогдох Гомдол шийдвэрлэх БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/100 дугаар |

| | | | |
|---|---|---|---|
| | холбогдох гомдол шалгах журмыг тодорхой болгон шинэчлэн баталж мөрдөх | | тушаалаар байгуулагдсан “Гомдол хянах ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгээр тендер зохион байгуулалттай холбоотой гомдол хянан шийдвэрлэгдэнэ. Иймд дахин худалдан авах ажиллагаанд холбогдох гомдол шалгах журмыг тодорхой болгон шинэчлэн баталж мөрдөх шаардлагагүй гэж үзэж байна.<br>Төслийн худалдан авах ажиллагааны удирдамжийн 2.6 дахь хэсэгт заасан гомдол шийдвэрлэх, хугацаа, процесст дүн шинжилгээ хийж, захиалагч тал, санхүүжүүлэгч талтай хэлэлцсэний дүнд “Худалдан авах ажиллагаанд холбогдох гомдол шалгах журам”-ыг Гомдол хянах ажлын хэсгийн үйл ажиллагааны чиглэлд заалтаар тусган оруулах боломжтой. Иймд дээрх зөвлөмжийн дагуу захиалагч талд 2025 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар танилцуулж ажилласан. Төслийн 12 дугаар сард зохион байгуулагдах 21 дэх удаагийн удирдах хорооны хуралд санал хэлэлцэхээр төлөвлөж байна. |
| 3 | Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх Үйлчилгээ, Ажил, Үйлдвэрийн Байгууламж, Барааны болон Зөвлөх бус Үйлчилгээ, Худалдан Авах ажиллагааны Удирдамжийн 1.2.1 “Үндсэн зарчим болох Өргөдөл гаргагч/Тендерт оролцогч нарыг Тендерийн ажиллагаанд оролцох ижил тэнцүү боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлэх” | | Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс зарлаж буй тендерийн зар урилгыг захиалагч тал, ТХН-ийн албан веб сайт, сошиал цахим хуудас болон үндэсний tender.gov.mn сайтад нээлттэй байршуулан боломжит өргөдөл гаргагч, тендерт оролцогч нарыг ижил тэнцүү оролцох нөхцөл боломжоор ханган ажиллаж байна. Цаашид тендерийн ажиллагаанд оролцох ижил тэнцүү боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах болно. |

**Хавсралт-3**

**Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төслийн зөвлөх багийн 2022-2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн дүгнэлтийн тайлбар, зөвлөмжийн биелэлтийн тайлан, мэдээлэл**

(2025 оны 12 дугаар 03-ны өдрийн байдлаар)

| **Эко консалт зепп-бусакер болон gitec-igip хамтарсан зөвлөх компанитай 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "зөвлөх ажлын гэрээ"-ний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тайлбар, мэдээлэл** | | | |
|---|---|---|---|
| **№.** | **Аудитын тайланд өгөгдсөн дүгнэлт, зөвлөмж** | **Хавсралт, эх сурвалж** | **ЭКО Консалтын хариу/ тайлбар** |
| 1 | Тус яамнаас ЭКО Консалт Зепп-Бусакер болон gitec-igip хамтарсан зөвлөх компанитай 2020 оны 2 дугаар сарын 29-нд байгуулсан "Зөвлөх ажлын гэрээ", 2022 оны 7 сарын 7-нд байгуулсан гэрээний нэмэлт өөрчлөлттэй танилцсан. | Зөвлөхийн гэрээ ба нэмэлт өөрчлөлтүүд | Зөвлөхийн гэрээний Нэмэлт өөрчлөлтийг **2022 оны 9 дүгээр сарын 26**-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>Нэмэлт өөрчлөлтийг дагалдах бичгийн хамт 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Яаманд хүргүүлж **2022 оны 9 дүгээр сарын 26-нд БОАЖЯ-ны ТНБ-ийн дарга Э.Баттулга гарын үсэг зурж баталгаажуулсан** |
| 2 | 2024 оны зарцуулалтын тайлан:<br>ЗБ: 1.9 сая евро | | Энд дурдсан тоо баримт буруу байна. ЗБ-ийн **2024 оны зарцуулалт 0.46 (460,532.82 евро) сая евро** байсан. |
| 3 | Шаардсан баримт бичгүүд 2.:<br>Зөвлөх ажлын гэрээ-ний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан ажил, үйлчилгээний төлөвлөгөө, тайлан ирүүлээгүй. | Ерөнхий нөхцөл § 3.4.1 ба Зөвлөхийн Гэрээний Тусгай нөхцөл 3.4.1<br>Ажлын даалгаварт зааснаар (Хавсралт 2):<br>• Эхлэлийн тайланг төсөл хэрэгжиж эхэлснээс 6 сарын дараа хүргүүлэх<br>• Эхний жилийн ҮАТ-г Эхлэлийн тайланг хүргүүлснээс хойш 3 сарын дотор боловсруулах. Дараагийн ҮАТ-нүүд ыг 2, 3, 4, 5, 6 ба 7 дахь жилд тус бүр боловсруулах;<br>• Төслийн хэрэгжилттэй холбоотой бүхий л асуудлыг тусгасан ХЖТ болон санхүүгийн | §3.4.1-д улирлын тайлан, болон ажил үйлчилгээ дуусгавар болсны дараа эцсийн тайлан гаргаж өгнө гэж заасан.<br>Улирлын болон хагас-жилийн тайланг Захиалагчид болон санхүүжүүлэгч KfW -д тогтмол хүргүүлж байсан болно.<br>Эхлэлийн тайланг – 2020.10.01-нд<br>ХЖТ № 1 – 2021.01.18-нд<br>ХЖТ № 2 – 2021.07.23-нд<br>ХЖТ № 3 – 2022.01.18-нд<br>ХЖТ № 4 – 2022.08.16-нд<br>ХЖТ № 6 – 2023.03.15-нд<br>ХЖТ № 7 – 2023.09.15-нд<br>ХЖТ № 8 – 2024.01.25-нд<br>ХЖТ № 9 – 2024.07.27-нд<br>ХЖТ № 10 – 2025.04.14-нд |

| | | | |
|---|---|---|---|
| | | тайлан боловсруулах, Захиалагчаар батлуулах (Хэрэгжилтийн тайлангууд);<br>• Зөвлөхийн гэрээний талаар улирлын товч тайлан боловсруулж Захиалагч болон KfW-д танилцуулах;<br>• Төсөл хэрэгжиж дуусахад Зөвлөх нь үзүүлсэн үйлчилгээний товч танилцуулга болон бусад холбогдох баримт бичгийн хамт эцсийн тайлан боловсруулж өгөх. Зөвлөх нь төслийн үйл ажиллагааг эцэслэж дууссанаас хойш 6 долоо хоногоос илүүгүй хугацаанд эцсийн тайлангийн төслийг танилцуулна. Тайлангийн эцсийн хувилбарыг Захиалагч / KfW -аас санал хүсэлт авснаас 4 долоо хоногийн дотор хүргүүлнэ.<br>• Төслийн хэрэгжилтийн явцын талаарх товч тайланг эрэлт хэрэгцээнд үндэслэн шаардаж болно. Тодорхой сэдвүүдийн хүрээнд тайланг ихэнхдээ богино-хугацааны зөвлөхүүд даалгавраа гүйцэтгэсний дараа боловсруулж Захиалагч/KfW-д хүргүүлдэг. ХЖТ-нд Зөвлөх нь дараах асуудлуудыг тусгана:<br>• Жил бүрийн ҮАТ-ний явцын талаар,<br>• Жил бүрийн ХАТ-ний явцын талаар, | УТ № 1 – 2021.04.20-нд<br>УТ № 2 – 2021.10.25-нд<br>УТ № 3 – 2022.05.12-нд<br>УТ № 4 – 2022.10.21-нд<br>УТ № 6 – 2023.10.20-нд<br>УТ № 7 – 2024.04.13-нд<br>УТ № 8 – 2024.12.03-нд тус тус хүргүүлсэн.<br>Бүх техникийн тайлангууд, түүнчлэн богино-хугацааны зөвлөхүүдийн боловсруулсан тайлангуудыг тухайн цаг үеийн явцын тайлангуудад хавсаргасан бөгөөд тайлан тус бүрээс лавлах боломжтой. Бүх явцын тайлангууд хавсралтын хамт Яаманд хүргэгдсэн болно.<br>Тиймээс ямар ч төлөвлөгөө, тайлан ирүүлээгүй гэсэн дүгнэлт нь үндэслэлгүй болсон байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | • Жил бүрийн төсвийн гүйцэтгэл / БОЯБХУАӨДЗТ-ийн төсвийн зарцуулалт,<br>• Төслийн бодит гүйцэтгэлийг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд болон баталгаажуулах арга хэрэгсэлтэй (Зөвлөх нь төслийн эхлэлийн шатанд Захиалагч болон ТХН-тэй хамтран боловсруулна) харьцуулсан үзүүлэлт. | |
| 4 | Шаардсан бичиг баримтууд Гэрээний Тусгай нөхцөлд заасан бусад тайлангууд ирүүлээгүй | Зөвлөхийн Гэрээний Тусгай нөхцөл 3.4.1 | № 3-т өгсөн хариуг үзнэ үү. |
| 5 | Шаардсан баримт бичгүүд 5.:<br>Холбогдох гэрээ, тайлан, санхүүгийн бүртгэлийг ирүүлээгүй. | Зөвлөхийн Гэрээний Тусгай нөхцөл 3.4.1 | ЭКО Консалт-аас 2025 оны 2 дугаар сарын 11-нд өгсөн хариу хүчинтэй хэвээр байна. Уг байр суурийг Яамтай хийсэн цахим уулзалт бүрд KfW банкнаас дэмжиж ирсэн. |
| 6 | Зөвлөх багаас "Зөвлөх ажлын гэрээ"-ний тусгай гэрээний 1.5-д заасан мэдэгдлийн дагуу 2021-2024 онд Захиалагч тал болох БОУАӨЯ-нд албан бичгээр болон мэйлээр 1.10.1 Гэрээний Тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол, Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын эзэмших бүх шилжүүлж болохуйц эрхийг шаардлага гарсан үед шилжүүлж байгаагүй бөгөөд хяналт шалгалтын ажлын хэсэгт ХШҮ-ний цахим системийн ашиглалтын байдал, үйл ажиллагаатай танилцах боломжоор хангаагүй, БОУАӨЯ-нд хүлээлгэж өгөх хугацаа болоогүй шалтгаанаар хойшлуулсан байна. | Зөвлөхийн Гэрээ ба Нэмэлт өөрчлөлтүүд | 2022 оны 5 дугаар сарын 9-ний Хурлын шийдвэрээр кластерын арга барилаас татгалзсаны дараа логфрэйм матриксийг шинэчилэх шаардлагатай болсон бөгөөд энэ ажил 2024 он хүртэл үргэлжилсэн. Үүний дараа ЗБ нь GIS системд суурилсан хяналт-үнэлгээний цахим системийг боловсруулж байгаа бөгөөд энд БОЯБХУАӨДЗТ-ийн 1-р шатны үр дүн орсон. Энд оруулсан зарим мэдээллийг баталгаажуулах шаардлагатай байгаа. 2025 оны 3 сард ЗБ нь ТХН-ийн Хяналт-үнэлгээний ажилтан болон ХЗ-дын ажилтнуудад сургалт зохион байгуулж Хяналт-үнэлгээний ажлын үзэл баримтлалын талаар танилцуулж, хэрэгжүүлэх дадлага хийлгэсэн. Аудит хийх үед ХҮ-ний системийг албан ёсоор хамтрагчдад шилжүүлэх хугацаа хараахан болоогүй байсан.<br><br>ХҮ-ний бүх ажлууд, түүнчлэн PowerBI dashboard системийг хөгжүүлж хөгжүүлэх ажил үргэлжилж байгаа |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ба бүрэн дуусаж ашиглалтад оруулсны дараа нэвтрэх боломжийг олгоно. |
| 7 | ХШҮ хийгдэхээс өмнө Богино болон Урт хугацааны зөвлөхүүдийн тайлангуудыг ирүүлээгүй нь Гэрээг зөрчсөн хэрэг болж байна. | Зөвлөхийн Гэрээ ба Нэмэлт өөрчлөлтүүд | Боловсруулагдсан бүх тайлангууд Улирлын болон хагас жилийн тайлангийн хавсралт маягаар хүргэгдсэн ба Яам үүнийг мэдэж байгаа. |
| 8 | Зөвлөх багаас 2021-2024 онд “Зөвлөх ажлын гэрээ”-ний 3.5.1 Зөвлөх үйлчилгээ үзүүлэхийн тулд үндсэн ажилтнууд болон тэдэнтэй холбоотой өөрчлөлт гарсан бол Захиалагч талд урьдчилан бичгээр зөвшөөрөл авч байгаагүй бөгөөд үндсэн ажилтныг сонгон шалгаруулах зарлалыг өдөр тутмын сонинд байршуулсан ба сонгон шалгаруулалт хэрхэн хийгдэж байгаа нь тодорхойгүй байна. | Зөвлөхийн Гэрээ § 3.5.1<br>Зөвлөх нь Үйлчилгээ үзүүлэхийн тулд Хавсралт 5-д [Боловсон хүчний ажиллах хуваарь] заасан ажилтнуудыг олж авна. Үндсэн ажилтнууд болон тэдэнтэй холбоотой ямар нэг өөрчлөлт гарсан бол Захиалагч болон KfW-аас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна. | Захиалагчид дараах өөрчлөлтүүдийн талаар мэдэгдсэн:<br>1. Төслийн ахлах зөвлөхөөр Хартмут Аббергерийг санал болгосон бөгөөд 2019 оны 2 дугаар сарын 29-ний өдөр Яамтай хийсэн гэрээнд дурдсан.<br>2. 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргад илгээсэн албан бичигт ноён Хартмут Аббергерийг Др. Граделаар солих болсныг мэдэгдсэн.<br>Сонгон шалгаруулалт нь ЭКО Консалт компаний дотоод үйл ажиллагаанд хамаарах ба Зөвлөхийн гэрээнд сонгон шалгаруулах журмын талаар заагаагүй болно. 3.5.3-т ажилтан шаардлага хангасан байхыг л шаарддаг: “Зөвлөх нь ажилтныг солих шаардлагатай бол шинэ ажилтан дор хаяж тухайн ажилтантай тэнцэхүйц ур чадвар эзэмшсэн байхад анхаарч, нэн даруй сольдог. |
| 9 | “Зөвлөх ажлын гэрээ”-нд БОУАӨЯ-ны бэлгэдлийг ашиглаж болох тухай заалт ороогүй байхад Зөвлөх багийн Ахлах зөвлөх Д.Галрагчаагийн нэрийн хуудас, зөвлөх багийн үндсэн ажилтан сонгон шалгаруулах зарлалыг өдөр тутмын сонинд нийтлэхдээ БОУАӨЯ-ны бэлгэдлийг ашигласан нь Засгийн газрын 2021 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Яамны бэлгэдлийг хэрэглэх” журмыг мөрдөөгүй. | ЗГ-ын журам, 2021 оны Тушаал №1, Хавсралт 1-ээр баталсан “Яамны билэг тэмдгийн ашиглалт” | Яамны билэг тэмдгийг Герман-Монголын хамтын ажиллагаа ба санхүүжүүлэгч тал KfW банкны бэлэг тэмдэгтэй хослуулан байнга ашиглаж ирсэн. Тайлан, илтгэл зэрэгт төслийн гол хамтрагчдыг (захиалагч/санхүүжүүлэгч) гадаад ертөнцөд таниулах зорилготой байсан.<br>Нэрийн хуудсан дээр гурвалсан бэлэг тэмдгийг ашигласан нь санаатай бус бөгөөд Яамны билэг тэмдгийг буруугаар ашиглах гэсэн хэрэг огт биш юм. Лого нь зөвхөн төслийн хүрээнд л ашиглагдаж байгаа болно. |
| 10 | “Зөвлөх ажлын гэрээ”-ний Ерөнхий нөхцөл 4.1-д заасны дагуу Зөвлөх багаас хавсралт 7-оор баталсан үйлчилгээгээ үзүүлж эхлэх тухай Захиалагчаас мэдэгдэл авч байгаагүй, ямар нэг өөрчлөлт гарсан тухай бичгээр хандаж | Зөвлөхийн Гэрээ § 4.1.2<br>Ямар нэгэн сонгосон үйлчилгээ байгаа бол энэ үйлчилгээгээ Зөвлөх нь Захиалагчаас KfW-аас | Төслийн бүхий л үйл ажиллагаа тухайн жилд Төслийн удирдах хороогоор баталсан төлөвлөгөөний дагуу явагддаг учир Захиалагчаас тусгайлан мэдэгдэл авах шаардлага гардаггүй. Тайланг тухай бүр хүргүүлж |

| | | | |
|---|---|---|---|
| | байгаагүй бөгөөд хавсралт 7 баталсан үйлчилгээний тайланг ирүүлж байгаагүй. | зөвшөөрөл авсан тухай мэдэгдэл авсны дараа эхлүүлнэ. | байсан тухай дээр зөвлөмж 3-ийн хариултад дурьдсан байгаа. |
| 11 | Article 3.4.1 of the Special Condition requires the Consultant to provide progress report to the “Зөвлөх ажлын гэрээ”-ний Тусгай нөхцөл 3.4.1-д “Тусгай Нөхцөлд заасны дагуу зөвлөх нь ажил гүйцэтгэлийн явцын талаар 1.5-д заасан мэдэгдлийн дагуу Захиалагч болон KfW-д тайлагнах үүргийн дагуу зөвлөх багийн зөвлөхүүдийн тайлан Захиалагч тал болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд ирүүлсэн бүртгэлгүй байна:<br>1. Төслийн үйл ажиллагааны бүхий л асуудлыг тусгасан хагас жилийн тайланг санхүүгийн тайлангийн хамт бэлтгэж ТХА-аар гарын үсэг зуруулах;<br>2. Зөвлөх үйлчилгээний талаар улирлын товч тайлан бэлтгэж ТХА-д тайлагнах;<br>3. Тодорхой чиглэлээр богино хугацааны зөвлөхүүдийн бэлтгэсэн тайлан. | Зөвлөхийн Гэрээний Тусгай нөхцөл:<br>3.4.1 Тайлан<br>№ 3-т өгсөн хариуг үзнэ үү | № 3-т өгсөн хариуг үзнэ үү |
| 12 | Ойн газрын албан бичгийн хавсралт болгон ирүүлсэн Техникийн нөхцөл ба санхүүгийн саналыг ямар ч өөрчлөлтгүйгээр хуулбарлан ЗБ-аас Ажлын даалгавар хэмээн ирүүлсэн. | Ойн албаны 2024 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01/286 дугаарт албан бичиг | Ойн ангиудыг багаж хэрэгслээр хангах ажил нь Ойн агентлагийн захиалгатай ажил учир Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх шаардлагын үүднээс хүссэн багаж хэрэгслийн тоо хэмжээ, техникийн үзүүлэлтийг албан тоотоор хүлээж авсан болно. Захиалагчийн хүссэн техникийн нөхцөлийг өөрчлөх эрх байхгүй. Захиалагч байгууллагын ирүүлсэн саналын дагуу Ажлын даалгаврыг ТХН ба ЗБ тендерийн шаардлагын дагуу боловсруулсан. |
| 13 | Гэрээний Ерөнхий нөхцөл 3.7.1-ийг зөрчсөн:<br>1. Др. А.Намхай, БХЗ нь “БОЯБХУАӨДЗТ II/III”-ийн 2022 оны ХАА-ны төлөвлөгөөнд орсон Сонгогдсон ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээг “Байгаль хамгааллын судалгаа хөгжлийн төв” НҮТББ-ийн нэрээр | Гэрээний Ерөнхий нөхцөл § 3.7.1: Зөвлөх болон Зөвлөхтэй холбоотой аль нэг байгууллага нь үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, барилгын гэрээлэгч зэрэг үүрэг хариуцлагатайгаар төсөлд оролцохгүй. Энэ нь цаашдын зөвлөх үйлчилгээнд саналаа | Зөвлөмжид дурдагдсан Зөвлөх үйлчилгээнүүд тендер нь нээлттэй сонгон шалгаруулалтаар явагдсан учир үүнд Зөвлөх багт хамааралгүй болно. |

| | | | |
|---|---|---|---|
| | гүйцэтгэгчээр шалгарч 62,736,300 төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн.<br>2. Сургалтын хэрэгцээний үнэлгээ хийх, чадавх дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах Эрдэнэбаярын Шинэцэцэг богино хугацааны зөвлөх нь “БОЯБХУАӨДЗТ-II/III” 2023 оны ХАА—ны төлөвлөгөөнд орсон ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн “Эко танхим”-ыг сургалтын гарын авлага, багаж хэрэгслээр хангаж, сургалт зохион байгуулах тендерт “Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” НҮТББ-ийн нэрээр гүйцэтгэгчээр шалгарч 738,292,098 төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн. | явуулахад ч хамаатай бөгөөд ингэсэн тохиолдолд энэ нь ашиг сонирхлын зөрчлийг үүсгэж байгаа болно. | |
| 14 | Зөвлөх нь Хавсралт 8-д баталсан урт, богино хугацааны зөвлөхүүдэд олгосон төлбөрийн баримтыг өгөөгүй болно. | Зөвлөхийн гэрээний Хавсралт 8:Зардлын тайлан | Хавсралт 8-д богино болон урт хугацааны зөвлөхүүд, ажилтнуудын цалин хөлс, төлбөрийг ил болгох нөхцөл заагаагүй болно. |
| 15 | Зөвлөх багт ажилладаг 5 ажилтан (нэрийг нууцалсан) ХШҮ-ний ажлын хэсэгт сайн дураараа “ЭКО Консалт Зепп-Бусакер болон Gitec-igip хамтарсан зөвлөх компани”-аас олгож байгаа цалин, нийгмийн даатгалын лавлагааг ХШҮ ажлын хэсэгт сайн дураараа гаргаж өгсний дагуу хянаж үзэхэд Гэрээний Тусгай нөхцөлийн 5.1.1-д, хавсралт 8-аар баталсан Орон нутгийн үндсэн мэргэжилтнүүдэд сард 2376евро олгох ёстойгоос сард 1500 орчим евро, 2090 евро олгохоос 1300 орчим евро олгож байгаа нь МУ-д ажилладаг үндсэн мэргэжилтнүүдэд төлбөрийг гэрээний дагуу шилжүүлдэггүй. | Аудитын тайланд эх сурвалжийг дурдаагүй болно. | Үйлчилгээ үзүүлэгч, Зөвлөх компаниуд мэргэжилтнүүд, ажилтнуудын нэмэгдэл зардлаас ашиг, орлого олох эдийн засгийн практикт нийтлэг үзэгдэл юм.<br>ЭКО Консалт нь ажилтнууд болон мэргэжилтнүүдийн гар дээр олгож буй цалин хөлснөөс гадна нийгмийн даатгалын болон бусад татварыг нэмж төлдөг болохыг хяналт-үнэлгээний баг анхааралгүй өнгөрөөжээ.<br>Дашрамд дурдахад ЭКО Консалт нь ажиллагсдынхаа татвар төлөх үүргээ үнэнч шударгаар биелүүлж ирсэн бөгөөд МУ-ын Татварын албанаас “Үнэ цэнэтэй, хариуцлагатай татвар төлөгч” гэх албан ёсны өргөмжлөлийг саяхан авсан билээ. 2024 онд ЭКО Консалт нь нийт 47,917,086 сая төгрөг төлж улсын болон орон нутгийн төсөвт хувь нэмэр оруулсан байна. |